


“Түмэн шувуут” ХК-ийн ТУЗ-ийн
2023 оны 42-р сарын 11-ний өдрийн
02/10/23 тоот тогтоолын хавсралт



“ТҮМЭН ШУВУУТ” ХК-ИЙН НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь “Түмэн шувуут” ХК-ийн /цаашид “компани” гэх/ Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс баримтлах ногол ашгийн бодлого, ногдол ашиг хуваарилах нөхцөл журмыг “Компанийн тухай хууль”, Монголын компанийн засаглалын кодекст нийцүүлэн тодорхойлоход оршино.
- 1.2 Төлөөлөн Удирдах Зөвлөл /ТУЗ/ нь “Ногдол ашгийн бодлого”-ыг нийтийн хүртээл болгох үүрэгтэй ба ТУЗ-ийн нарийн бичгийн дарга сонирхсон бүх этгээдэд уг баримттай танилцах боломж олгохоос гадна компанийн цахим хуудсанд байршуулсан байна.

Хоёр. Ногдол ашиг хуваарилах нөхцөл

- 2.1 Нэг төрлийн нэгж хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна.
- 2.2 Компани дор дурдсан тохиолдолд ногдол ашиг хуваарилж болно.
 - 2.2.1 компанийн тухайн жилийн цэвэр ашгийг тухайн жилийн дундаж өөрийн хөрөнгөнд харьцуулсан харьцаа 20 хувиас багагүй байх
 - 2.2.2 шийдвэр гаргах өдрийн байдлаарх зээлийн багцын чанар байдал
 - 2.2.3 ногдол ашиг төлсөний дараа компани төлбөрийн чадвартай байх
 - 2.2.4 ногдол ашиг төлсөний дараа компанийн өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногол ашиг, татан буулгах үед төлөх дүн, компанийн дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний нийлбэрээс илүү байх
 - 2.2.5 компани хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцаагаа эргүүлэх авах нөхцөл байдал үүссэн, өрийн бичгээ эргүүлэн худалдан авах хугацаа болсон бол эдгээр үнэт цаасыг бүрэн эргүүлэн авсан, эсвэл бүрэн худалдан авахад шаардагдах хөрөнгөтэй байх
- 2.3 Компани дараахи тохиолдолд заавал ногдол ашиг хуваарилна. Үүнд:
 - 2.3.1 Энэхүү бодлогын 2.2-т заасан нөхцөл хангагдсан
 - 2.3.2 Компани ашигтай ажилласан бөгөөд компанийн дүрэм, эсвэл хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт заасан компанийн нөөцийн болон хөрөнгө оруулалт, нийгмийн хөгжлийн санд зориулсан хуваарилалтыг бүрэн хийсний дараа хуваарилагдаагүй үлдсэн цэвэр ашгийн 20-иос доошгүй хувь

Гурав. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр

- 3.1 Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг тухайн жилийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулсанаас хойш 50 хоногийн дотор ТУЗ гаргана. ТУЗ шийдвэртээ нэгж хувьцаанд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг олгох хэлбэр, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр болон ногдол ашиг төлөх өдрийг тогтоож, энэ талаар хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулсан

мэдээлэлтэй хамт хүргүүлнэ. Энэ хэсэгт дурдсан бүртгэлийн өдөр нь Түмэн шувуут ХК-ийн “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-д заасан бүртгэлийн өдөртэй ижил байна.

- 3.2 Ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно.
- 3.3 Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг нийтэд мэдээлж, хувийг Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржийн мэдээллийн нэгдсэн санд хүргүүлнэ.
- 3.4 Жилийн тайлан тусгах мэдээлэлд ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон үндэслэл, төлөх журмын талаар бүрэн тусгасан байх бөгөөд ногдол ашиг хуваарилахгүйгээр шийдвэрлэсэн бол түүний үндэслэлийг энэ журмын дагуу тайлбарласан байна.
- 3.5 Компани ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн бол энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд заавал тайлагнах бөгөөд тайлбартаа ногдол ашиг хуваарилах боломжгүй байдалд хүрсэн шалтгаан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тайлбар зэргийг тусгасан байна.

Дөрөв. Ногдол ашиг хуваарилах, тайлагнах.

- 4.1 Ногдол ашиг төлөх хэлбэр, олгох хугацаа, журам нь хувьцаа эзэмшигчдэд аль болох тохиромжтой, эрх ашигт нийцсэн байна.
- 4.2 Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ногдол ашгийг ТУЗ-аас тогтоосон хугацаанд төлөөгүй тохиолдолд хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэлээр алданги төлөх бөгөөд үүнээс компанид учирсан хохирлыг тухайн компанийн гүйцэтгэх удирдлага нөхөн төлнө.
- 4.3 Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр гарсан бол төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдэд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд тусгах бөгөөд ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын эцэст ногдол ашгаа аваагүй байгаа хувьцаа эзэмшигч бүрийн нэрээр тусгайлан өглөгийн бүртгэл хөтөлнө.
- 4.4 Ногдол ашгийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигч бүрийн үнэт цаасны ногдол ашиг хүлээн авах банкны өөрийн нэр дээрх дансанд шилжүүлнэ.
- 4.5 Хувьцаат компани нь ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн жилийн ээлжит хуралд өмнөх жилийн ногдол ашиг хуваарилалтын тайланг танилцуулна.
- 4.6 Компани нь өөрийн цахим хуудсанд ногдол ашгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг байршуулна.